



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

┌ Үл хөдлөх хөрөнгө эзэмшүүлж, бүртгэх ┐
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Сангийн сайдын багцын VII.2-т баталсан (Татварын ерөнхий газрын захиалгаар) улсын төсвөөр санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 1,324,298,618.00 (нэг тэрбум гурван зуун хорин дөрвөн сая хоёр зуун ерэн найман мянга зургаан зуун арван найман) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэст эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005477
14-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн
233 дугаар тогтоолын хавсралт

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн үндсэн
хөрөнгөд бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Барилгын хүчин чадал	Гүйцэтгэлээрх дүн /төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Татварын хэлтсийн барилга (цогцолбор) /Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 6-р баг/	3 давхар, зоорьтой, нийт 1083.44м ²	1,324,298,618.00	2021-11-16 БУ-88/2021
	Нийт дүн		1,324,298,618.00 (нэг тэрбум гурван зуун хорин дөрвөн сая хоёр зуун ерэн найман мянга зургаан зуун арван найман)	